



**ХЭНТИЙ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРВАН ДОЛООДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 10

Чингис хот

┌ Аймгийн баяр наадмыг тэмдэглэн
өнгөрүүлэх хорооны бүрэлдэхүүн, дүрэм
батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арван долоодугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх салбар хорооны дарга, гишүүдийг томилон ажиллуулахыг аймгийн Засаг даргад, баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг аймгийн баяр наадмыг тэмдэглэх хорооны даргад тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 44 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Г.ХЭРЛЭНЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 17 дугаар хуралдааны 10 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт

АЙМГИЙН БАЯР НААДМЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: -Аймгийн Засаг даргын орлогч
- Орлогч дарга: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Нарийн бичгийн дарга: -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Гишүүд: -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга
-Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
-Цэргийн штабын дарга
-Цагдаагийн газрын дарга
-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр
нээлттэй хорих ангийн дарга
-Татварын хэлтсийн дарга
-Онцгой байдлын газрын дарга
-Биеийн тамир, спортын газрын дарга
-Соёл урлагийн газрын дарга
-Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
-Мал эмнэлгийн газрын дарга
-Хэрлэн сумын Засаг дарга
-Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ийн салбарын -
дарга
-Ардын дуу бүжгийн "Хан Хэнтий" чуулгын дарга
-"Хэнтий-Ус" ХХК-ийн захирал
-Харгуй "ТӨХК"-ийн захирал

---оОо---

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 02 дугаар сарын 02-ны
өдрийн 17 дугаар хуралдааны 10 дугаар
тогтоолын 02 дугаар хавсралт

АЙМГИЙН БАЯР НААДМЫГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмээр Үндэсний их баяр наадмыг хууль тогтоомж, уламжлалт ёс заншил, өв соёл, орчин үеийн технологид тулгуурлан аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах, аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хорооны үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хороо (цаашид "Хороо" гэх) нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний их баяр наадмын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Биеийн тамир спортын тухай хууль бусад хууль тогтоомж, энэ дүрэм, холбогдох стандартыг мөрдөж ажиллана.

Хоёр.Хорооны удирдлага, зохион байгуулалт

2.1.Хороо нь орон тооны бус байх бөгөөд дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2.Хорооны Ажлын албаны үүргийг Аймгийн Засаг даргын тамгын газар гүйцэтгэнэ.

2.3.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанд нийт гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

2.4.Хорооны дарга нь хуралдааны дэгийг тогтоож, хуралдааныг удирдах бөгөөд түүний эзгүйд орлогч дарга бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

2.5.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж тогтоол гаргаж, тогтоолд Хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.6.Хуралдааны явцын тэмдэглэл хөтөлж, Хорооны нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтан гарын үсэг зурна.

2.7.Хороо нь дараахь салбар хороотой байна:

2.7.1.Үндэсний бөхийн салбар хороо;

2.7.2.Хурдан морины салбар хороо;

2.7.3.Сурын харвааны салбар хороо; /үндэсний, урианхай, буриад сурын хорооны дэд хороотой байж болно/

2.7.4.Шагайн харвааны салбар хороо;

2.7.5.Урлаг, соёлын салбар хороо;

2.7.6.Зочид, төлөөлөгчдийг угтах, хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах салбар хороо;

2.7.7.Хэв журмын салбар хороо;

2.7.8.Худалдаа, үйлчилгээний салбар хороо;

2.7.9.Хэвлэл, мэдээллийн салбар хороо.

2.7.10. Санхүү төсөв, аж ахуйн салбар хороо

2.7.11. Бүтээн байгуулалт, тохижилт, засвар үйлчилгээний салбар хороо

2.8. Салбар хороо нь Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

2.9. Салбар хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд тэмдэглэлээр баталгаажуулна.

Гурав. Хорооны бүрэн эрх

3.1. Хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хариуцан баяр наадмын нээлт, хаалт, үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сурын болон шагайн харваа, төрийн ёслол, хүндэтгэл, соёлын арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу зохион байгуулах;

3.1.2. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, аймгийн Засаг даргын өмнө ажлаа хариуцан тайлагнах;

3.1.3. Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зарим үйл ажиллагаа, арга хэмжээг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулах

3.1.4. Салбар хорооны бүрэлдэхүүнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрхийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар батлах;

3.1.5. Хорооны болон салбар хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлж, тайланг хэлэлцэх;

3.1.6. Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулах, салбар хороодоос гаргасан төсвийн төслийг хэлэлцэж хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих;

3.1.7. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар зохион байгуулсан ажил, санхүүгийн тайланг баяр наадам дууссанаас хойш ажлын 7 өдөрт багтаан авч нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.1.8. Баяр наадамд оролцож байгаа бөх, уяач, харваач, уралдаанч хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон холбогдох бусад этгээдээс гаргасан гомдол, саналыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх;

3.1.9. Баяр наадмын шагналын үнэмлэх, урилга, тасалбар, зөвшөөрлийн загварыг батлах.

3.2. Хороо нь дараахь асуудлаар холбогдох төрийн байгууллагад санал гаргах эрхтэй:

3.2.1. Аймгийн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулж, санал авах;

3.2.2. Салбар хороодын төсөвт өөрчлөлт оруулах;

3.2.3. Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд идэвх зүтгэл, санаачилгатай ажилласан хүмүүст мөнгөн шагнал олгох, бусад хэлбэрээр урамшуулах, төр, засгийн шагналаар шагнуулах тухай саналаа холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

3.2.4. Хороо болон салбар, дэд хорооноос өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн гишүүн, албан тушаалтанд хариуцлага тооцуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал хүргүүлэх.

3.3. Үндэсний бөхийн салбар хороо нь дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Дүрэм батлах” тухай 257 дугаар тогтоолын

2 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний бөхийн барилдааны дүрэм”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3.2. Үндэсний бөхийн барилдаантай холбоотой маргааныг шийдвэрлэнэ.

3.3.3. Аймаг байгуулагдсаны тэгш ой тохиосон жилийн баяр наадмын үндэсний бөхийн барилдааны өмнө аймгийн цол олгох барилдааныг зохион байгуулж болно.

3.4. Хурдан морины салбар хороо нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.4.1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Дүрэм батлах” тухай 257 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний хурдан морины уралдааны дүрэм”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4.2. Үндэсний хурдан морины уралдаантай холбоотой маргааныг шийдвэрлэнэ.

3.4.3. Дээрх дүрмийн 4.1-т заасны дагуу хурдан морины уралдааны зайг газар нутгийн байршил, цаг агаарын байдал, малын тарга хүч, бусад нөхцөл байдлыг харгалзан дүрэмд заасан холбогдох байгууллагын саналыг үндэслэн салбар хуралдаанаар хэлэлцэж тогтоно.

3.5. Сурын салбар хороо нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.5.1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Дүрэм батлах” тухай 257 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Үндэсний сурын харвааны дүрэм”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5.2. Аймгийн баяр наадмаар үндэсний сурын харваанаас гадна буриад, урианхай, өсвөрийн сурын харвааг зохион байгуулж болно. 50 хувиас дээш оносон харваачдад мөн адил урамшуулал олгох ба аймгийн цол олгохгүй.

3.5.3. Сурын харваатай холбоотой маргааныг шийдвэрлэнэ.

3.6. Үндэсний шагайн салбар хороо нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.6.1. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн “Дүрэм батлах” тухай 257 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний шагайн харвааны дүрэм”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6.2. Шагайн харвааг ахмад, насан хүрэгчид гэсэн төрлөөр зохион байгуулах ба ахмад настны шагайн харвааг зөвхөн чавхны харваагаар зохион байгуулна. №№

3.6.3. Үндэсний шагайн харваатай холбоотой маргааныг шийдвэрлэнэ.

Дөрөв. Хариуцлага

4.1. Хороо нь ёс зүй, сахилга хариуцлагын дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.